

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Эдийн засгийн загварчлал хариуцсан ахлах мэргэжилтэн, Наранцогт Наранцацралт

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна.							
1	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан.	-	Засгийн газраас баримтлах тэргүүлэх чиглэлийг тодорхойлон УХЖТ-ний төсөлд тусгасан. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024.04.10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд 14 дүгээр тэмдэглэлд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу 2024.04.30-ны өдөр "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

122

					<p>тухай” УИХ-ын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлсэн. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг Улсын Их Хурлын Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.</p> <p>Хавсралт: 1 файл</p>		
2	<p>Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг гүйцэтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлнэ.</p>	<p>Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө” батлуулсан.</p>	-	<p>Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд 2025 оны төсөөллийг хийж, танилцуулгад тусгасан. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024.04.10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд 14 дүгээр тэмдэглэлд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу 2024.04.30-ны өдөр “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын дарга</p>	<p>1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар</p>	100%

					Г.Занданшатарт хуулийн хугацаанд өргөн мэдүүлж, батлагдсан. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоололд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн тооцооллыг хийж гүйцэтгэсэн. Хавсралт: 1 файл		
3	Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан.	Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2025 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулсан байна/ 1 танилцуулга/	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд макро эдийн засгийн нөхцөл байдлын танилцуулгыг хийж гүйцэтгэж 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хурал баталсан. 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч "Монгол Улсын 2025 оны төсвийн тухай" хуульд бүхэлд нь хориг тавьж, хоригийг УИХ хүлээн авсан. Үүнтэй холбогдуулан УИХ-ын Ёс зүй, дэгийн байнгын хороо Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг УИХ-аар яаралтай хэлэлцэх чиглэлд анхаарч "Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>тогтоол баталж, 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Үүний дагуу 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг Засгийн газарт танилцуулахад шаардагдах макро эдийн засгийн тооцоо, төсөөллийг боловсруулан танилцуулж, УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэн ажиллаж байна.</p> <p>Хавсралт: 1 файл</p>		
<p>1.2. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.</p>							
4	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулж, танилцуулна.	Дүн шинжилгээний тоо	Өмнөх онуудын эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн.	2024 оны 2, 3 дугаар улирлын танилцуулга бэлтгэсэн байна.	2023 оны жилийн эцэс, 2024 оны 1-3 дугаар улирлын макро эдийн засгийн нөхцөл байдлын шинжилгээ (Macro diagnostics) хийж, монгол болон англи хэл дээр тайлан боловсруулж, 2024 оны жилийн эцэс, 2025-2027 оны макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөллийг шинэчлэх ажил үргэлжилж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>Тус тайланд Статистик өгөгдлийн урьдчилсан мэдээнд тулгуурлан үйлдвэрлэлийн функцийн арга, калманы шүүлтүүрийн арга, ходрик фрескотын аргад үндэслэн эдийн засгийн потенциал өсөлт, бодит өсөлтийг тодорхойлж 2023 оны үйлдвэрлэлийн зөрүүг тооцож удирдлагад танилцуулан тусгасан. Мөн тус тайлангуудад Хөдөө аж ахуйн салбарын төсөөлөл, хөдөлмөр үйлдвэрлэлийн бодит ахиу зардлын хамаарал, гурилын тариф, квот, нүүрсхүчлийн үнэ тогтоох талаар шигтгээ хийж тусган оруулсан. Үйлдвэрлэлийн аргаар тооцон гаргасан дотоодын нийт бүтээгдэхүүний хөдөө аж ахуй, боловсруулах, мэдээлэл холбоо, санхүү болон даатгалын үйл ажиллагаа, барилга, үл хөдлөх зэрэг салбаруудын гүйцэтгэлд тулгуурлан нөхцөл байдлын дэлгэрэнгүй шинжилгээ хийсэн. Калманы шүүлтүүрийн аргаар тооцоолон гаргасан үр дүнд</p>		
--	--	--	--	--	--	--	--

					тулгуурлан бодит хүү, бодит ханш, үйлдвэрлэлийн бодит ахиу зардалд тулгуурлан санхүү, хөдөлмөрийн зах зээлийн дүгнэлтийг гаргаж нийт эрэлтийн хэсэгт тайлагнан дүгнэж оруулсан. Хавсралт: 4 файл		
5	Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана.	Хөгжүүлсэн загварын тоо	Мэдээллийн дата баазыг бүрдүүлж, туршилт тооцооллуудыг гүйцэтгэсэн.	Загвар хөгжүүлсэн байна /1 загвар/	1. FPP загвар хөгжүүлэх сургалтад хамрагдсан ба ОУВС-ийн Казакстан дах сургалтын байгууллагын сургагч багш нарыг урьж загварыг хамтран хөгжүүлэх ажил хийгдсэн. 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг FPP загварт оруулан 2025 оны төсөөллийн нийцлийг хангаж ажилласан. Уг загварт тулгуурлан Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн хүрээний макро эдийн засгийн тооцоо, төсөөллийг хийх боломж бүрэн бүрдсэн. 2. Мөнгөний бодлогын шинжилгээний GAP загварыг ашиглан филипсийн тэгшитгэл дэх бодит ахиу зардлын хэсгийг онолд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>тулгуурлан хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан урьдчилсан хамаарлыг нийт болон салбар тус бүрийн хувьд тодорхойлсон бөгөөд нийт -35 хувь буюу сул сөрөг хамааралтай байгааг тодорхойлоод байна. Бодит ахиу зардал дах бодит ханшийн нөлөөг үнэлэх замаар барилга, тээвэр, боловсруулах, худалдааны салбарын хөдөлмөрийн зах зээлийн төсөөллийг боловсруулах боломж бүрдсэн. Мөн тус загварыг өргөтгөн уул уурхайн болон уул уурхайн бус салбарын GAP-г калманы шүүлтүүрийн аргаар тооцон эхний үр дүнг гарган авсан бөгөөд төсвийн тэлэлтийг гадаад шок байдлаар загварт өгч эдийн засаг дах нөлөөг үнэлэх шинжилгээний хөгжүүлэлтийг хийж ажилласан.</p> <p>Хавсралт: 1 файл</p>		
6	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр	Мэдээллийн тоо /Тоо/	Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн.	Тухай бүр мэдээллээр хангасан байна.	Сарын танилцуулгад эдийн засгийн өсөлт, хөдөө аж ахуй, аж	1-р сар, 2-р сар, 3-р сар,	100%

105

	мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.			/тухай бүр/	үйлдвэр, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, боловсруулах салбарын үйлдвэрлэлийн хэмжээ болон гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг тусган, хэвлэх, хавтаслах ажлуудад тогтмол оролцож байна. Тус мэдээ нь сар бүр яамны цахим хаяг дээр тогтмол нийтлэгдэж олон нийтийг мэдээллээр хангаж байна. Хавсралт: 1 файл	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
7	Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана.	Мэдээллийн тоо /Тоо/	Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн.	Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/	Power BI ашиглан өдөр тутмын зах зээлийн мэдээллүүдийг тухай бүрд нь шинэчлэн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
8	Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт)	Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн.	Тайланд ашигласан тоо	Улирлын тайланд ашигласан байна.	Гааль, И-баримтын датаг сар бүрт тогтмол авч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого, НӨАТ-ын шивсэн баримтын тоонд тулгуурлан үйлчилгээний	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар,	100%

					салбарын гүйцэтгэлтэй уялдуулан төсөөллийг сайжруулж байна. Тус шинжилгээ Сарын танилцуулгад нэмэгдэн орсон ба удирдлагыг холбогдох мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
9	Эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгааг боловсруулна.	Судалгааны тоо	Судалгаанд шаардлагатай тоон мэдээллийг цуглуулсан.	Судалгаа боловсруулсан байна. /1 судалгаа/	Урт хугацааны хандлагын тайланд нийт үйлдвэрлэлийн хэсгийг хариуцан гүйцэтгэсэн Хавсралт: 1 файл	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
1.3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлнэ.							
10	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан.	-	МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙНХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ хууль 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан. Харин Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт орсны дагуу төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах хуулийн төслийг бэлтгэн 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хурал баталсан. Улсын Их	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					Хуралд тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг бэлтгэх чиглэлд макро эдийн засгийн холбогдох үзүүлэлтүүдийн төсөөллийг нягтлан, гүйцэтгэл гарах тутамд шинэчлэн төсөөллийг сайжруулах чиглэлд анхаарч ирэх жилд өргөн барих төсвийн хүрээний мэдэгдлийн баримт бичгийн бэлтгэлийг ханган ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	-	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна.	ОУВС-ын "Макро-эконометрикийн бодлогын таамаглал ба дүн шинжилгээ" богино хугацааны сургалт, мөн ОУВС-ын Төв Азийн бүс хариуцсан мэргэжилтнүүдийн зохион байгуулагдсан "Санхүүгийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	100%

					програмчлал (FPP)" сургалтад туслах багшаар ажилласан. Мөн БНХАУ-ын Далиан хотноо зохион байгуулагдах "Бүс нутгийн интеграц дахь эдийн засгийн асуудлууд" сэдэвт сургалтад хамрагдсан.	11-р сар, 12-р сар	
2	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	-	Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна	Мэдээллийн цагт амралт, томилолт, хуралтай үеэс бусад цагт тогтмол хамрагдан холбогдох мэдээллийг авсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эдийн засгийн загварчлал хариуцсан ахлах мэргэжилтэн, Наранцогт Наранцацралт / *Н. Наранцацралт* /

Огноо: 2024.12.18

187